

Саяхан хуралдсан ХКН-ын XIII их хурал Хятад орон социализмын эхний шатанд байгаа тухай, энэ шатан дахь нийгмийн үндсэн зөрчил бол ард түмний өсөн нэмэгдэж буй материаллаг болон соёлын хэрэгцээ, нийгмийн үйлдвэрлэлийн хоцрогдол хоёрын хоорондох зөрчил болох тухай тодорхой заан тэмдэглэсэн билээ. Энэхүү зөрчлийг социализмын эдийн засгийн үндсэн хуулийн мөн чанартай харьцуулан харуулахын хамт Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн үндсэн зөрчлийг шийдвэрлэх асуудлыг авч үзсэн байна. Үүнээс үзэхэд тодорхой хэсэг хугацаанд нийгмийн гол зөрчил гэж байсан ангийн тэмцэл хойш тавигдах болсныг харууллаа.

Энэхүү асуудал нь юуны өмнө эдийн засаг, улс төр, нийгэм, оюуны амьдрал зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд шинэчлэлт хийж, эдийн засаг, соёлын хөгжлийг төлөвлөсөн хурдцад хүргэж чадах эсэхээс шалтгаална. ХКН-ын энэхүү бодлогод янз бүрийн хүчин зүйлсийн нөлөөллийг тал бүрээс нь авч үзсэн бөгөөд тухайлбал аж ахуйн олон хэвшил, хөдөлмөрийн техник зэвсэглэмжийн түвшин дорой, хүн амын болон хөдөлмөрийн нөөцийн ихээхэн өсөлт зэргээр тодорхойлогдож байна.

ХКН улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хурдац, түвшин, бүтэц, үр ашгийг онцлон үзжээ. Нийгмийн үйлдвэрлэлийг явуулахдаа социалист таваарын эдийн засгийг төлөвлөгөөтэй хөгжүүлэн ард түмний өсөн нэмэгдэж буй материаллаг болон оюуны хэрэгцээг хангахдаа юуны өмнө амьдралын доод түвшингээс чинээлэг байдалд хүргэх хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

БНХАУ дахь төлөвлөгөөт таваарын эдийн засагт аж ахуйн янз бүрийн хэвшил байх боловч социалист сектор давамгайлна гэдгийг авч үзсэнийг тэмдэглэх нь зүйтэй. Энэ бүхнийг хамааруулан хятадын нийгэм эдийн засгийн хөгжлийн зарим талуудыг авч үзье.

Эдийн засгийн өсөлтийн явц, хандлага

Өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн гол үзүүлэлт болох нийгмийн нийт бүтээгдэхүүн, үндэсний орлого нь БНХАУ-д 1979—1986 онуудад (үнийн одоогийн ханшаар) 2,59 дахин, харин зэрэгцүүлсэн үнээр 95,1 хувь¹ өссөн байна. Үндэсний орлогын жилийн дундаж цэвэр өсөлт 8,7 хувьд² хүрч байгаа нь түүний биет хэмжээ өндөр хурдацтай нэмэгдсэнийг харуулж байна.

Хэдийгээр нийгмийн үйлдвэрлэл эрчимтэй нэмэгдэж байгаа боловч Хятадын эдийн засагт үндэстний орлогын үйлдвэрлэлийн зардал өндөрсөх явдал байгаа юм. Энэхүү хандлага нь нийгмийн үйлдвэрлэл дэх материал зарцуулалт эрс нэмэгдсэнээр илэрч байна. Хэрэв 1978 онд үндэсний орлогын 1 юаньд (үнийн өнөөгийн ханшаар) 1,274 юаний материалын зардал гаргаж байсан бол 1986 онд 1,434 юанийг зарцуулжээ. Материал зарцуулалт ингэж өссөнөөр үйлдвэрлэлийн хэрэгслийг ихээ-

хэн өсгөх гол хүчин зүйл болох материаллаг зардлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгоно. Эндээс нийгмийн нийт бүтээгдэхүүний өсөлт, үндэсний орлого ба материаллаг зардлын харьцаа муудаж ирсэн нь харагдаж байна. 1919—1986 онд нийгмийн нийт бүтээгдэхүүн одоогийн үнийн ханшаар 2,8 дахин, зэрэгцүүлсэн үнийн ханшаар 2,2 дахин нэмэгджээ. 1986 онд БНХАУ-ын ННБ (одоогийн ханшаар) 1896, 1 млрд юань, үндэсний орлого 779 млрд³ юаньд хүрчээ. 1987 онд үндэсний орлогын хэмжээ 915,3 млрд юань болж⁴, нийгмийн нийт бүтээгдэхүүний хэмжээгээр Хятад улс дэлхийн эхний 10 орны тоонд орсон байна. 1986 онд БНХАУ үр тариа мах, хөвөн, цемент үйлдвэрлэлтээр дэлхийд эхний байранд, нүүрс олборлолтоор 2 дугаар байранд тус тус оржээ⁵.

Эдийн засгийн өсөлтийн хурдцыг нь бусад оронтой харьцуулан судалж үзэхэд 1981—1985 онд үндэсний орлогын өсөлтийн явцаар социалист орнуудын дотор төдийгүй дэлхийд тэргүүлж байна. Үндэсний орлогын мэдэгдэхүйц өсөлт хуримтлалын болон хэрэглээний фондыг нэмэгдүүлэх эрэлт шаардлагыг хангах дотоод чухал хүчин зүйл болж байна.

Хятадын эдийн засгийн өсөлтийн түвшинд гарсан ахиц

Сүүлийн жилүүдэд Хятадын нийгэм давшингүй хөгжсөний дүнд нэг хүнд оногдох үндэсний орлого нэлээд нэмэгдэв. Хэрэв 1978 онд нэг хүнд оногдох үндэсний орлого 315 юань байсан бол 1986 онд 741⁶ юаньд хүрснээр 2,4 дахин нэмэгджээ. Хэрэв үнэ ханшны зөрүүг гаргаж үзвэл 77 хувь (жил бүр 7,4 хувь) өссөн бөгөөд энэ ч бас ихээхэн өндөр хурдац юм. Гэсэн ч Хятад улс одоо эдийн засгийн буурай хөгжилтэй орны тоонд орж байна. .

БНХАУ-ын үндэсний орлогын өсөлтөд нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн зэрэгцээ хүн амын ажил эрхлэлтийн байдал сайжирсан явдал багагүй үүрэгтэй билээ. Тус орны эдийн засаг дахь нөхөн үйлдвэрлэлийг түлхүү байдлаар явуулахад шаардлагатай хуримтлалын норм (хэм хэм жээ) хуримтлалын болон хэрэглээний фондын хооронд харьцаа алдагдаж эхлэх тийм хэмжээ хязгаарт хүрээд байна. Энэ нь үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус салбарын материал техникийн бааз ихээхэн өргөжсөнийг мөн харуулж байна. Хуримтлалын өндөр норм нь үйлдвэрлэлийн үндсэн ба эргэлтийн фондын өндөр өсөлтийг тодорхойлж байна. Үүний дүнд хөдөлмөрийн фонд зэвсэглэмж түргэн хурдацтай нэмэгдэж, түүний цэвэр өсөлт нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөс давах болов. Ийм таагүй харьцаа бүрэлдсэний улмаас хятадын эдийн засагт фонд өгөмж буурах үйл явц үргэлжилж байна.

Ийм нөхцөлд нийгмийн үйлдвэрлэлийн материал зарцуулалтын өсөлт, фонд өгөмж буурах явдлыг нөхөж чадахуйц хэмжээгээр нийгмийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх нь эдийн засгийн хувьд зохистой гэж үздэг. Харин хятадын эдийн засаг дахь нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт үйлдвэрлэлийн хэрэгсэл дэх нэмэлт зардлыг нөхөж чадахгүй байгаа тул хангалтгүй байна. Иймээс хөрөнгө мөнгөний гадаад эх сурвалж, гадаадын капитал олж авахад чиглэсэн «нээлттэй хаалганы бодлого» идэвхтэй явуулж байна. Энэ бүхэн Хятадын эдийн засгийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлд нөөц баялгийг хэтрүүлэн зарцуулах хүчин зүйлс давамгайлж, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийг гол төлөв экстенсив аргаар явуулж байгааг илтгэж байна. Ийнхүү нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт хангалтгүй, фонд өгөмж буурч, үйлдвэрлэлийн материал зарцуулалт өсч байгаа зэрэг нөхөн үйлдвэрлэлдэх янз бүрийн зохисгүй хандлага нь

хятадын эдийн засгийн үр ашгийн түвшин хөгжингүй орнуудын эдийн засгийн үр ашгийн түвшинд ойртох чиглэлд бус, харин нэлээд холдуулж болзошгүй юм.

Хятадын эдийн засагт үнийн хүчин зүйлийн нөлөөлөл, үр дагавар

Дээр өгүүлсэнчлэн тус орны нийгмийн нийт бүтээгдэхүүн хийгээд үндэсний орлогын мөнгөн хэмжээ, түүний биет хэмжээнээс улам бүр тасран холдож байна. Энэ байдал улам бүр хүчтэй болж хятадын эдийн засгийн нөхөн үйлдвэрлэл дэх харьцаа алдагдуулах явдлыг нэмэгдүүлэх болов. Үүнийг судлаачид мөнгөний ханш буурах үйл явц гэж нэрлэдэг. Үнэ мөнгөний хэмжээ (эквивалент) биет хэмжээнээс тасран холдох байгаагийн нэг илрэл бол үнэ, ялангуяа үйлдвэрлэлийн хэрэгсэл, ард түмний хэрэглээ, үйлчилгээний зүйлийн үнэ асар их өсөх явдал юм.

Хятадад материал, түүхий эд, түлш, эрчим хүчний нөөц, хүнсний бүтээгдэхүүн, хэрэглээний зүйлс ихээхэн эрэлт хэрэгцээтэй байна. Одоо юмны үнэ нэгдэх явдал тогтмол шинжтэй болон хувирч үүний улмаас хөрөнгө оруулалт, жижиглэн худалдаалах бараа гүйлгээ, материал зарцуулалт хэт өсч байгааг өнөөгийн байдал харуулж байна. Энэ нь БНХАУ-ын улс ардын аж ахуйн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн үндсэн харцааг ихээхэн алдагдуулж байна.

Тус оронд одоо үйлчилж буй үнийн систем нийт болон цэвэр бүтээгдэхүүний өртгийг тусгаж чадахаа больсныг хэлэх хэрэгтэй. Улсаас эрэлт хэрэглээг зохицуулах, үнийн зохисгүй хандлагыг зогсоож чадахгүй байгаа бөгөөд үйлдвэрийн газрын алдагдал, үнийн зөрүүг нөхөхөд ихээхэн хөрөнгө мөнгө гаргаж байна. Энэ зорилгоор 1985 онд Хятадын засгийн газар улсын төсвөөс 48 млрд. юань, 1986 онд 32,2 млрд юань гаргажээ. 1986 онд үнийн зөрүүг нөхөх татааст 28 млрд юань зарцуулсан байна. Юмны үнэ өсөх үйл явц хуримтлалын болон хэрэглээний норм ихээхэн нэмэгдэхэд хүргэжээ.

Хятадын эдийн засгийн бүтэц

Хятад улсад үйлдвэрлэлийн харилцаа, эдийн засгийн бүтцийн олон хэлбэр үйлчилж байна. Социализмын эхний шатны бүхий л хугацаанд орших өмчийн олон хэлбэр нь аж ахуйн олон хэвшлийг нөхцөлдүүлэн бий болгож байв. Нийгмийн өмч (бүх ард түмний, хоршооллын)-ийн зэрэгцээ хамт олны, хувийн, хөрөнгөтний зэрэг (хамтарсан ба гадаадын капитал) өмчийн хэлбэрүүд бий. Өмчийн ийм бүтэц нь ажиллах хүчнийг үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй холбох арга хэлбэрт төдийгүй нэмүү бүтээгдэхүүний өртөг хуваарилах хэлбэрт ч өвөрмөц байдлаар нөлөөлдөг.

Хятадын эдийн засгийн салбар бүрд аж ахуйн хэвшил бүрийн өвөр мөц харьцаа бүрэлдэн тогтсон байдаг. Гэхдээ тус орны эдийн засагт үндэсний орлогод эзлэх хувийн жин нь буурсан боловч социалист сектор урьдын адил зонхилсон хэвээр байна. Хятад орны эдийн засгийн хүч чадал, хөгжлийн түвшин түүний хурдцаас нь шууд хамаарах социалист сектор үйлдвэрлэлд бас гол үүрэг гүйцэтгэж байна. Үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин доогуур, нийгмийн хөдөлмөрийн хуваарь хангалттай хөгжөөгүй явдал бол үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх олон хэлбэртэй байхын бодит нөхцөл юм. Мөн түүнчлэн олон янз бүтэцтэй эдийн засаг нь аж ахуйн хэвслүүдийн эдийн засгийн ашиг сонирхол зөрчилдөх эх

үүсвэр болж байна. Хувийн аж ахуй хөгжин, гадаадын хөрөнгө мөнгөөр болон гадаадынхантай хамтран байгуулсан үйлдвэр аж ахуйн газар бий болсноор хөлсний хөдөлмөр, ажиллах хүчийг мөлжих, нэмүү өртгийг капитал болгоход хүргэж байна. Энэ бүхний улмаас өмчийн ялгаа ихэсч байна.

Аж ахуйн олон хэвшил хамтдаа байхад эдийн засгийн нэгдсэн механизм бус, хэвшил бүрийн ашиг сонирхлыг харгалзсан аж ахуйн нийлмэл механизм шаардлагатай. Ийм нөхцөлд төвлөрсөн төлөвлөлтийн үүргийг бууруулж зах зээлийн аргаар зохицуулах уу, эсвэл зах зээлийн зохицуулалтыг идэвхтэй ашиглан төвлөрсөн төлөвлөлтөөр зохицуулах уу гэсэн асуудал хурцаар тавигдах болов. Байдлаас үзвэл зах зээлийн зохицуулалтын арга хятадын эдийн засгийг эрхлэн хөтлөх системд улам бүр гол үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь социалист төлөвлөгөөт таваарын аж ахуйн үзэл баримтлалын мөн чанараас үүдэн гарч байгаа юм.

Хятадын эдийн засгийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн бүтцийг авч үзэхдээ хэвлэлд нийтлэгдсэн нэгэнт үйлдвэрлэсэн үндэсний үнэмлэхүй хэмжээ, ашигласан үндэсний орлогын үнэмлэхүй хэмжээнээс хавьгүй бага байгаа нь анхаарал татаж байна. Үйлдвэрлэсэн, ашигласан үндэсний орлогын энэхүү зөрүү нь капитал, байшин барилга, машин, тоног төхөөрөмж, технологид зориулан гадаадаас зээл авах зэрэг гадаад эх сурвалжтай холбоотой юм.

80-аад онд Хятад улс гадаад бүх эх сурвалжаас 55 млрд долларын хөрөнгө мөнгө татан оруулжээ. Гадаадаас оруулсан энэ бүх мөнгө зээлийг хятадын эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, гадаадын тэр гүүний техник, технологи олж авахад ашиглаж байна. Гадаад өр, зээлийн хүүг төлөхөд Хятад улс жил бүр экспортын 15 хувийг зарцуулж байгаа бөгөөд энэ харьцааг хэвийн, онц аюулгүй гэж үзэж байна. Энд гадаадын техник, технологийн үнэ өсөх хандлагатай байгааг харгалзан үзэх хэрэгтэй. Гадаад өрийн төлбөр болон экспортын харьцааг тодорхойлохдоо хэдий хэмжээний өрийг төлж байгаад бус, харин гадаад өр, зээлийн хүүгийн хэдэн хувийг төлж байгаа, мөн түүнчилэн зээлийн хүүг өндөржүүлэх хүчин зүйлийг чихэд анхаарах хэрэгтэй. БНХАУ-ын хувьд ашигласан үндэсний орлогын бүтэц төдийгүй, үндэсний орлого бүрдүүлэх эх сурвалжийн бүтэц ч чухал юм.

БНХАУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг хэрхэн үзэх тухай асуудлын зарим тал

2000 он хүртэлх хугацаанд хоцрогдол, хөгжингүй байдлын зөрүүг багасган, улс орноо дунд зэргийн хөгжлийн түвшинд ойртуулах чухал алхам хийх зайлшгүй шаардлага, томоохон зорилт хятадын нийгмийн өмнө тулгарч байна. Энэхүү зорилтын зангилаа асуудал бол үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх явдал бөгөөд хятад дахь өөрчлөлт, шинэчлэлт ч үүнд чиглэж байгаа билээ. Үйлдвэрлэх хүчний хөгжлийн өндөр хурдцыг хангах явдал өмчийн олон хэлбэртэй социалист төлөвлөгөөт таваарын аж ахуй, өөрөөр хэлбэл нийгмийн үйлдвэрлэлийн хөгжилтэй шууд холбогдож байна. Энэ нь гадаад харилцаагаа өргөтгөж, улс төрийн ардчиллыг боловсронгуй болгон, оюуны соёлыг хөгжүүлэхийг шаардаж байна. Ийм учраас Хятад улсын үндсийн үндэс болсон дөрвөн үндсэн зарчмыг хатуу баримтлах нь тулгамдсан асуудал болсон юм.

Нийгмийн хоцрогдсон бүтцийг өөрчилж, хөгжингүй байдалд хүрэх хөгжлийн замд гарахын тулд давшингүй өндөр хурдцыг ханган үр ашгийг

байнга дээшлүүлэн, бүтцийг өөрчилж, нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшний тэнцвэртэй харьцаа тогтоох асуудал Хятадын эдийн засагт хурцаар тавигдаж байна. Юуны өмнө 1979-1987 онуудын хөгжлийн өндөр хурдцаа Хятад улс 1991-2000 онуудад хэвээр хадгалж чадах эсэх асуудал тулгарч байна. Өндөр хурдац цаашид хэвээр байна гэхэд хэцүү бөгөөд 1991-2000 онуудын эдийн засгийн өсөлтийн хурдац 1981-1990 онуудынхаас буурах төлөвтэй байна. Асуудлын гол нь Хятадын эдийн засгийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийн өсөлтийн хурдац ХХ зууны сүүлчийн арван жилд ямар хэмжээнд хүртэл буурах вэ гэдэгт оршино.

1979-1986 онд үндэсний орлогын биет хэмжээ 95,1 хувь (жилд 8,7 хувь), нэг хүнд оногдох хэмжээ 77,4 хувь (жилд 7.4 хувь) өссөн билээ. БНХАУ-ын нийгмийн үйлдвэрлэл ихээхэн өндөр хурдацтай хөгжиж ирсэн боловч үе шат бүрд харилцан адилгүй өсөлтийн хурдац байсан нь тодорхой. Ирэх арван жилд БНХАУ-ын үндэсний орлогын биет хэмжээний өсөлтийн хурд бидний үзэж байгаагаар жил бүр 5 хувийн түвшинд байх болов уу? Нэг хүнд оногдох үндэсний орлого 4 хувиас дээш байна. Энэ нь хэдийгээр өсөлтийн өндөр үзүүлэлт биш боловч дундаж үзүүлэлтээс дээгүүр юм.

Ихээхэн цар хүрээ бүхий хятадын эдийн засгийн хувьд үндэсний орлогын өсөлтийн хурдцыг дундаас дээгүүр түвшинд байлгах нь амаргүй асуудал бөгөөд цаашдаа цэвэр өсөлтийн хувь бүр ихээхэн төвөгтэй болж ирнэ. Тэгээд ч БНХАУ хөрөнгө оруулалт, жижиглэн худалдаалах бараа гүйлгээний нийт хэмжээний харьцаа ихээхэн эгзэгтэй цэгт тулж очоод байна.

Хөгжлийн түвшнийг харуулах гол гол үзүүлэлтүүдийн уялдаа холбоо, тэдгээрийг ихээхэн нэмэгдүүлэх явдал бүр ч хэцүү байдалд ороод байна. Үүнтэй холбогдуулан БНХАУ-ын эдийн засгийг хөгжүүлэх чухал хүчин зүйлийг оновчтой сонгох явдал маш их ач холбогдолтой болж байна. Тухайлбал, үндэсний орлогын өсөлтийн зонхилох хэсгийг нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөр хангах шаардлагатай. Материал түүхий эд, хөрөнгө оруулалт, импорт, гадаад өрийг машинд багасгахад чиглэсэн арвилан хэмнэх, хянаж зохицуулах бодлого явуулах нь нэн тулгамдсан асуудал болжээ. Үйлдвэрлэлийн материал зарцуулалтын өсөлтийг зогсоож цаашид нэлээд бууруулах нь чухал. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөд, хөдөлмөрийн хэрэгслийн үр ашиг буурах явдлыг сааруулж чадахуйц үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, шинэчлэх нь тохиромжтой.

Үндэсний орлогын хэмжээ хүн амын тооноос шууд хамаардаггүй, харин нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, хүн амын хэсэг болох (ажиллах хүч хөдөлмөрийн нөөцийн үйлдвэрлэл эрхэлж буй байдлын түвшинг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог. Нийгмийн хөдөлмөрийн бүтээмж нь зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгслийн үр ашиг, техникийн түвшин, ажиллагсдын мэргэжил мэдлэгээр төдийгүй өмчийн хэлбэр бүтэц, нийгэм-үйлдвэрлэл, нийгэм-анги, төр-эрхийн харилцааны боловсорсон байдал, улс ардын аж ахуйг удирдах арга, механизм, нийгэм-эдийн засгийн урамшууллын систем зэргээр тодорхойлогддог.

Одоо Хятад оронд болж байгаа нийгэм эдийн засаг дахь өөрчлөлтийн үйл явцаас үзвэл дээр дурдсан хүчин зүйлүүдийг зохицуулах үүднээс тал бүрийн арга хэмжээ авч байгаа нь ажиглагдаж байна.

1. «Хунци» 1987. № 19 хуудас 23-24
2. Мөн тэнд
3. «Хунци» 1987 19 х-23
4. «Жэньминь жибао» 1988. II. 24
5. «Хунци» 1987 № 19 х-24
6. «Хунци» 1987 № 19 х-23

ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ХОЛБОО (АСЕАН)-НЫ ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСАГ

Ч. СУВД

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал бүхэлдээ, Зүүн өмнөд Азийнх тусгайдаа ихээхэн анхаарал татах боллоо. Үүний учир шалтгаан нь нэгд Ази номхон далайн сав нутагт дэлхийн хүн амын ихэнх нь амьдардаг, 33 улс оршдоогоороо, хоёрт эдгээр орнуудад дэлхийд нээж олсон хөнгөн цагааны 56%, никель цайрын 41%, кобальтын 37%, зэсийн 32%,¹ далайн ёроолын нефть, хийн боломжит нөөцийн 30—40 %² нь болон бусад ашигт малтмалын ихээхэн нөөц байгаа, мөн дэлхийн худалдааны эргэлтийн гуравны нэгээс илүү оногдож байгаагаар, гуравт НҮБ-ын мэргэжилтнүүдийн тооцоолсноор дэлхийн аж үйлдвэрийн нэгэн том төв болох ирээдүйтэйгээр, дөрөвт дэлхийн II дайнаас хойш АНУ-аас хийсэн хоёр том дайн (Солонгос, Энэтхэг-Хятадын хойгт) болсон төдийгүй өнөө хэр нь «халуун цэг», «маргаантай асуудал» гэгчийн учиг сэжүүр болж ирснээр тайлбарлагдана.

Зүүн өмнөд Ази нь Номхон далайн орнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, аюулгүй байдалд төдийгүй, даян дэлхийн энх амгаан, аюулгүй байдалд хүртэл нөлөөлж, том, жижиг, улсуудын ашиг сонирхол огтолцож мөргөлдсөн бүс нутаг юм. Тус бүс нутагт дэлхийн социалист хоёр том гүрэн-ЗСБНХУ, БНХАУ, мөн дэлхийн капитализмын гурван тулгуурын хоёр нь болох АНУ, Япон хил залган оршдог. Мөн үүний хамт арал ольтригийн жижиг улсууд ч бий.

Нэг үе дэлхийн энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлэл бий болж, нэг үе итгэл найдвар, хэвийн амьдрал ээлжлэн солигдож байлаа. «Долгион» маягийн тэсрэмтгий шинж нь дэлхийн олон нийтийн, тэр дундаас Ази тивд оршдог манай орны анхаарлыг зүй ёсоор татдаг юм.

Бруней, Индонез, Малайз, Сингапур, Тайланд, Филиппиныг багтаасан АСЕАН-ын орнууд нь Ази номхон далайн орнуудын түгшүүртэй байдлыг намжаах, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд эдийн засаг, улс төрийн томоохон хүч мөн. Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнууд нь бүс нутгийн төдийгүй даян дэлхийн улс хоорондын харилцаанд хүндтэй